



“ДӨРВӨН БЭРХ” ЦОМ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Уулын спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн уулын спортын хөгжилд хувь нэмрээ оруулах, уул усаа хүндлэх эрхэм зорилгын хүрээнд 1. Монгол Алтай нурууны ноён оргил Хүйтэн /д.т.д 4374 м/, 2.(а) Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр /д.т.д 4008 м/, (б) Говь-Алтай нурууны оргил Их Богд /д.т.д 3957м/, 3. Хэнтийн нурууны ноён оргил Асралт /д.т.д 2799 м/, 4.Соёны нурууны ноён оргил Мөнхсарьдаг /д.т.д 3491 м/ оргилуудад тус тус амжилттай авиралт хийсэн уулчныг батламжлах, улмаар уулын спортыг олон нийтэд сурталчилахад оршино.
- 1.2. Энэхүү журмын 1.1.-д заасан уулсын оргилуудад амжилттай авиралт хийсэн уулчдыг батламжлах хэлбэр нь цом байх бөгөөд “Дөрвөн бэрх” нэртэй байна /цаашид “цом” гэх/.
- 1.3. “Дөрвөн бэрх” цомыг олгохдоо тэгш, шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтална.
- 1.4. “Дөрвөн бэрх” цомны зохиогчийн эрхийг Монголын Уулчдын Үндэсний Холбоо /цаашид “Холбоо” гэх/ эзэмшинэ.

ХОЁР. ЦОМНЫ ХЭЛБЭР, ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Цомыг энэхүү журамд заасан шалгуурыг хангасан уулчдад нээлттэй олгоно.
- 2.2. Цомыг үнэмлэх, энгэрийн тэмдэг дагалдана.
- 2.3. Цомны загвар нь энэхүү журмын Хавсралт №1-д заасны дагуу байна.

ГУРАВ. ЦОМ ОЛГОХ ЖУРАМ

- 3.1. Цомыг эзэмших болзол хангасан уулчныг Холбооны гишүүн байгууллагууд, холбоо, клуб, байгууллага, хувь хүн өөрөө нэр дэвшүүлж энэхүү журмын 3.2-т заасан бичиг баримтыг бүрдүүлэн Холбоонд өгсөнөөс хойш ажлын 10 хоногт багтаан олгоно.
- 3.2. . Монгол Алтай нурууны ноён оргил Хүйтэн /д.т.д 4374 м/, 2.(а) Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр /д.т.д 4008 м/, (б) Говь-Алтай нурууны оргил Их Богд /д.т.д 3957м/,

3. Хэнтийн нурууны ноён оргил Асралт /д.т.д 2799 м/, 4.Соёны нурууны ноён оргил Мөнхсарьдаг /д.т.д 3491 м/ оргилуудад амжилттай авиралт хийсэн уулчид дараах материалыг бүрдүүлэн Холбооны ажлын албанд sg@mountain.mn цахим хаягаар хүргүүлнэ. Үүнд:

- a. Цом эзэмшигчийн анкет /Хавсралт №2/
- b. 4 оргилд амжилттай авиралт хийсэн батламжны хуулбар;
- c. Оргил тус бүр дээрх фото зураг/бичлэг;
- d. Цомны төлбөрийг төлсөн баримт

3.3. Цомыг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн олгох бөгөөд дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- a. Нөхөн олгож өгөхийг хүссэн өргөдөл;
- b. Цомны төлбөрийг төлсөн баримт;

ДӨРӨВ. ЦОМЫН ТӨЛБӨР

- 4.1. Цомны төлбөрийг Монголын Уулчдын Үндэсний Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар тогтооно.
- 4.2. Цомны төлбөрийг цомыг эзэмшихээр горилж буй уулчин бүрэн хариуцна.

ТАВ. БУСАД

- 5.1. Холбоо нь цом эзэмшигчдийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай байна.
- 5.2. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг МУҮХолбооны ажлын алба хариуцан ажиллана.
- 5.3. Болзол хангаж цом авсан уулчдын талаар МУҮХ-ны вэб хуудсанд байрлуулж өдөр тутмын мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилж нийтэд зарлан мэдээлнэ.

_____оОо_____

“Дөрвөн бэрх” цом олгох журмын Хавсралт №1

